

## 10.Төсвийн ерөнхийлөн захирагч-аймгийн Засаг даргаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт

Аймгийн Засаг дарга нь ТБУСТХууль болон Төрийн албаны зөвлөлийн 87 дугаар тогтоолын дагуу тухайн төсвийн жилд хийж хэрэгжүүлэх ажлыг чиг үүргийн дагуу гүйцэтгүүлэхээр сумдын Засаг дарга нартай бүтээгдэхүүн нийлүүлэх санжүүжилтийн гэрээ, эрхлэх хүрээний 23 агентлаг, байгууллагын дарга нартай Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээ байгуулан ажилласан байна.

Гэрээний нэг тал болох аймгийн Засаг дарга 4 сард албан тушаалаасаа өөрчлөгдсөн тул шинээр томилогдсон Засаг дарга Ё.Баатарбилэг сумдын Засаг дарга нартай байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан дахин баталгаажуулалт хийсэн.



Уг гэрээнд аймгийн хэмжээнд тулгамдсан гол асуудал болох санхүү, төсвийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх, төрийн байгууллагын ил тод шуурхай байдлыг хангах, хадлан тэжээл бэлтгэх, ногоон тэжээл тариалах, мал сүргийг тарилга туулганд бүрэн хамруулах зэрэг ажлуудыг тусгай захиалгат бүтээгдэхүүн болгон оруулжээ.

**Үүний үр дүнд албан байгууллагуудын санхүүгийн баримтын зөрчил багасч, өвөлжилтийн бэлтгэл ажил харьцангуй сайн хангагдсан байна.**

Агентлагын дарга нартай Төсвийн тухай хууль, 2010 оны нийгэм эдийн засгийн Үндсэн чиглэл, Засгийн газрын болон орон нутгийн түвшинд баримталж байгаа бодлого зорилт, хөтөлбөрүүдийг үндэслэн журмын дагуу гэрээ байгуулж хэрэгжилтийн явц, үр дүнг 2 удаа хяналт шинжилгээ хийж дүгнэлээ.

Ерөнхий менежерийн гэрээнд Засаг даргын албан даалгавар, захирамжаар өгсөн үүрэг даалгавар, авлигатай тэмцэх, шударга ёс, ил тод байдлыг хангах арга хэмжээг зохион байгуулах, төсвийн удирдлагын менежментийг зөв удирдаж бүртгэл хяналтын тогтолцоог бүрдүүлэх зорилтуудыг тусгай захиалгат бүтээгдэхүүн болгон тусгасан. Гэрээний биелэлтэнд хяналт шинжилгээ хийхэд дараахи нийтлэг зүйл илэрсэн.

Үүнд: **Ололт амжилт:**

Байгууллагуудын баримт бичгийн эмх цэгц, албан хэрэг хөтлөлтийн ажлын зохион байгуулалт сайжирч, бичиг хэрэг хариуцсан ажилтнуудын үүрэг хариуцлага дээшилсэн байна.

Төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдэлт, дотоод журмын хэрэгжүүлэлт нь төрийн байгууллагын хэмжээнд мөрдөх журам зааврын дагуу сайн хийгдэж байна.

Онцгой байдлын хэлтэс, Хүүхдийн төлөө хэлтэс, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар ,Эрүүл мэндийн газар зэрэг байгууллагууд ажилтнуудынхаа ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, ая тухтай орчинг бүрдүүлэх, тохижилт соёлжилтын асуудалд ахиц өөрчлөлт гарсан байна.

Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар зохион байгуулж шийдвэрлэсэн болон төлөвлөж буй ажлаа ойлгомжтой тодорхой болгож орчин үеийн техникийн ололт дэвшлийг ашиглан дүрсжүүлж мэдээллийн сангаа бүрдүүлсэн нь бусад төрийн байгууллагуудад санаа авахуйц ололт амжилт юм.

“Төсөв санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх тухай” аймгийн Засаг даргын захирамжийн дагуу нябо бүртгэл, санхүү хөрөнгийн орлого, зарлагын мэдээ, тайланг хугацаанд нь чанартай гаргаж хэвшсэн байна.

**Алдаа дутагдал:** Төрийн албан хаагчдыг чадваржуулах, санаачлагатай шуурхай ажиллах, амжилтыг урамшуулан дэмжих ажил орхигдож байна.

Шинэчлэлийг мэдрэх, үйл ажиллагаандаа бүтээлчээр хэрэгжүүлэх талаар дутмаг байна.

Ил тод байдлыг хангах тухай Засгийн газрын 143 дугаар тогтоолд заасан зорилтуудыг бүрэн бүтэн санаачлан хийсэн байгууллага алга. Тухайлбал байгууллагын үйл ажиллагаатай холбоотой төрийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээ товч тодорхойлж, иргэдэд үзэж танилцаж болох нээлттэй мэдээлэл материалын жагсаалт гаргаагүй, хүний нөөцийн стратегийг тодорхойлоогүй, байгууллагын төсвийн гүйцэтгэл, тайлан мэдээг ил тод байрлуулаагүй, худалдан авах болон авсан бараа ажил үйлчилгээний тухай мэдээг цахим хуудас болон мэдээллийн самбарт тавиагүй байна.Үндсэндээ уг тогтоолын үндсэн агуулга хэрэгжиж эхлээгүй байна.

Иргэдийн өргөдөл гомдол, албан бичгийн шийдвэрлэлтэнд хяналт тавьж шуурхай хариу өгөх ажил ГХБХБХ, УБХ зэрэг зарим томоохон агентлагуудад дутагдалтай байна. Ажлын байранд шинжилгээ хийж байгаа тул ажлын байрны тодорхойлолт хуучнаараа ажил үүрэг давхардсан, хуваарилалт жигд бус байна.

Татварын хэлтэс, МХГ, НДХ,ХХААЖДҮГ, БОАЖГ –ын удирдлагад төрийн албан хаагчийн шалгалт өгөөгүй, тэнцээгүй хүмүүсийг ажилд томилж Төрийн албаны тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Агентлагуудын ажил, Менежерийн үр дүнгийн гэрээний биелэлтийн талаар тухайн байгууллага болон Тамгын газрын харъяа хэлтэс дээр хэлэлцэн, **дүнг Засаг даргын Зөвлөлд танилцуулан, үнэлгээг Засаг дарга өгсөн нь гэрээний хариуцлагыг өндөржүүлж, цаашид ахиц өөрчлөлт гарахад түлхэц болсон байна.**

Аймгийн Засаг даргын Тамгын газраас Менежерүүдийн гэрээнд хяналт шинжилгээ хийж үнэлгээ өгөхдөө бодит байдлыг газар дээр нь очиж үзэж танилцах, хэрэглэгчийн үнэлгээтэй харьцуулах , ярилцлага хийх зэрэг аргуудыг хослуулан хийсэн тул үнэлгээг бодитой дүгнэгдсэн.

Аймгийн Засаг даргаас Ерөнхий менежерүүдтэй байгуулсан үр дүнгийн гэрээг дүгнэсэн үзүүлэлтийн үнэлгээ

	агентлаг	Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээний биелэлт			Оноо Гэрээний нийт оноо
		Нийт бүтээг-дэхүүн /30оноо/	Тусгай захиалгат бүтээг-дэхүүн /40 оноо/	өмчлөг-чийн эрх /30 оноо/	
1	Татварын хэлтэс	28.6	38	29.5	<b>96.1</b>
2	Статистикийн хэлтэс	28.5	38.3	30	<b>96.8</b>
3	Цагдаагийн хэлтэс	26.4	36	30	<b>92.4</b>
4	У/ бүртгэлийн хэлтэс	28	36	25	<b>89</b>
5	ШШГ алба	25.5	38	30	<b>93.5</b>
6	ШШ алба	24	37.2	30	<b>91.2</b>
7	Э.М-ийн газар	22.3	33	30	<b>85.3</b>
8	НД хэлтэс	28	32	20	<b>80</b>
9	ХХҮ-ний хэлтэс	27	36	20	<b>83</b>
10	БТСын газар	27	36	30	<b>93</b>
11	ХТ хэлтэс	30	34,5	30	<b>94,5</b>
12	Б/ соёлын газар	28,4	36,7	28,3	<b>93,4</b>
13	Номын сан	30	37.2	30	<b>97.2</b>
14	ХД театр	26.8	25.3	25	<b>77.1</b>
15	ГХБХБ газар	28	28	26	<b>82</b>
16	ХХААЖДҮ газар	25	32	25	<b>82</b>
17	БОАЖ-ын газар	25	32	25.5	<b>80.5</b>
18	СХЗхэлтэс	Удирдлага нь солигдсон тул дүгнээгүй			
19	МХГазар	26.4	34	28.3	<b>88.7</b>
20	УЦУОШТ	28	32	28	<b>88</b>
21	Музей	28.8	31.6	29.2	<b>89.6</b>
22	ГАЗамын газар	26	30	25.	<b>81</b>
23	ОБХэлтэс	28	33	29	<b>90</b>
24	Цэцэрлэг станц	30	36.6	28.3	<b>94.9</b>
	Дүн				<b>88,6</b>

Хяналт шинжилгээ үнэлгээний тасаг.